

2.Хүнсний ногоо, таримал мөөг, цэцэг, гоёл чимэглэлийн таримал: Хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээг бүгд дүн, усалгаатай талбай, хүлэмжийн талбай гэсэн ангиллаар 24-51 дүгээр мөрөнд өгөгдсөн хүнсний ногооны нэр төрөл бүрээр асууж бүртгэнэ.

1 дүгээр баганад тухайн жилд үр суулган, тариалалт хийсэн нийт талбайн дүнг асууж нөхнө.

2 дугаар баганад усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалалтын явцад ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайн хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. **(Багана1≥багана2)**

3 дугаар баганад хүлэмжид тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Хүлэмж гэдэг нь хөрсийг хамгаалж, таримал ургамал ургуулах зорилгоор барьсан байгууламжийг хэлнэ. Хүлэмжийн талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж тавина. **(Багана1≥багана3)**

24-46 дугаар мөрөнд хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Хүнсний ногооны тариалсан талбайг байцаа, лууван, шар манжин, улаан манжин, сонгино, саримс, өргөст хэмх, улаан лооль, тарвас, амтат гуа, хулуу, чинжүү, амтлагч ногоо, цэцэгт байцаа, брокколи, шанцай, цоохор майлз, бууцай, юуцай, бусад ургамлын тариалсан талбай гэсэн төрлөөр ангилан бүртгэнэ. Амтлагч ногоонд гоньд, яншуй гэх мэт орно. **(Мөр24=мөр(25:46))**

47 дугаар мөрөнд таримал мөөгний тариалсан талбайн хэмжээг асууж бүртгэнэ.

48-51 дүгээр мөрөнд цэцэг, гоёл чимэглэлийн таримлыг цэцгийн үр, цэцэг, бусад гэсэн ангиллаар нөхнө. **(Мөр48=мөр(49:51))**

Тариалсан талбайн хэмжээг га-гаар илэрхийлэх бөгөөд өөрөөр илэрхийлсэн тохиолдолд доор өгөгдсөн итгэлцүүрийг ашиглан га-д шилжүүлнэ.

Талбайг га-д шилжүүлэх итгэлцүүр:

$$1 \text{ га} = 10000\text{м}^2 = 100\text{м} \times 100\text{м}, 1 \text{ сот} = 100\text{м}^2 = 10\text{м} \times 10\text{м}, 100 \text{ сот} = 10000\text{м}^2 = 1 \text{ га}$$

Үндэсний статистикийн хороо
Эдийн засгийн статистикийн газар
Холбоо барих утас: 51-261565

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 12 -р сарын 25-ны өдрийн А/190 дугаар тушаалын V хавсралтаар батлав.

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн мэдээллийн нууцыг хадгална.

А-ХАА-6

ТАРИАЛСАН ТАЛБАЙН 20 ... ОНЫ ... САРЫН ЯВЦЫН МЭДЭЭ

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.Байршил	Нэр										Код	
Аймаг, нийслэл												
Сум, дүүрэг												
Баг, хороо												
2.Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл												
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр												
Регистрийн дугаар												
Утасны дугаар												
3.Өрхийн мэдээлэл												
Өрхийн тэргүүлэгчийн овог, нэр												
Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар												
Утасны дугаар												

1. Баг/хорооны засаг дарга аж ахуйн нэгж, байгууллага, өрхөөс мэдээг авч сум, дүүрэгт 5, 6, 7-р сар бүрийн 01-ний дотор маягтаар ирүүлнэ.

2. Сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан, дүүргийн статистикийн хэлтэс нь 5, 6, 7-р сарын 02-ны дотор аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст сум, дүүргийн нэгтгэлийг цахим хэлбэрээр дамжуулна.

3. Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс 5, 6, 7-р сарын 04-нд Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр дамжуулна.

II. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

1. Үр тариа, төмс, таримал тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал, бусад

ГА-ГААР

Үзүүлэлт	МД	Код	Тариалсан талбай, бүгд	Усалгаатай талбай
				2
А	Б	В	1	2
Үр тариа <i>мөр1=мөр(2:8)</i>	1	0110000		
Буудай	2	0111100		
Арвай	3	0115100		
Овьёос	4	0117100		
Хөх тариа	5	0116100		
Бог будаа	6	0118100		
Гурвалжин будаа	7	0119200		
Бусад	8	0119900		
Төмс	9	0151000		
Таримал тэжээлийн ургамал <i>мөр10=мөр(11+12+14+15)</i>	10	0191000		
Ногоон тэжээл	11	0191900		
Даршны ургамал	12	0191200		
Эрдэнэшиш	13	0191100		
Олон наст	14	0191911		
Бусад	15	0191990		
Техникийн ургамал <i>мөр16=мөр(17:20)</i>	16	0140000		
Рапс	17	0144300		
Чихрийн манжин	18	0180100		
Наранцэцэг	19	0144500		
Бусад	20	0149900		
Хадлан	21	0191931	х	
Эмийн ургамал	22	0193000		
Бусад	23	0199000		

2. Хүнсний ногоо, таримал мөөг, цэцэг, гоёл чимэглэлийн таримал

ГА-ГААР

Үзүүлэлт	МД	Код	Тариалсан талбай, бүгд	Усалгаатай талбай	Хүлэмжийн
А	Б	В	1	2	3
Хүнсний ногоо <i>мөр24=мөр(25:46)</i>	24	0120000			
Байцаа	25	0121200			
Лууван	26	0125110			
Шар манжин	27	0125120			
Хүрэн манжин	28	0125500			
Сонгино	29	0125310			
Сармис	30	0125200			
Өргөст хэмх (урт)	31	0123211			
Өргөст хэмх (давжаа)	32	0123212			
Улаан лооль	33	0123400			
Тарвас	34	0122100			
Амтат гуа	35	0122900			
Хулуу	36	0123510			
Чинжүү	37	0123110			
Амтлагч ногоо	38	0165400			
Цэцэгт байцаа	39	0121300			
Брокколи	40	0121310			
Салатны навч /шанцай/	41	0121400			
Цоохор майлз	42	0129100			
Бууцай	43	0121500			
Юуцай /хятад байцаа/	44	0129200			
Хаш	45	0123300			
Бусад	46	0129000			
Таримал мөөг	47	0127000			
Цэцэг, гоёл чимэглэлийн таримал <i>мөр48=мөр(49:51)</i>	48	0196000			
Цэцгийн үр	49	0196300			
Цэцэг	50	0196200			
Бусад	51	0196900			

ТАМГА

Тайлан гаргасан. /

/

Тайлан хянасан. /

/

20... оны ...-р сарын ...-ны өдөр

**ТАРИАЛСАН ТАЛБАЙН ЯВЦЫН ... ОНЫ ... САРЫН МЭДЭЭ
(А-ХАА-6)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР**

Энэхүү маягтыг тухайн жилд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж, тариалалт хийсэн, өвс хадлан бэлтгэсэн өрх болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагаас тогтоосон хугацаанд нөхөж авна.

I.ХАЯГИЙН ХЭСЭГ

1.Байршил: Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн харьяалагдах аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, кодыг маягтын зааварт тусгасан засаг захиргааны нэгжийн кодоос харж нөхнө.

2.Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл: Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад УБЕГ-аас олгосон регистрийн дугаарыг бичнэ. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

3.Өрхийн мэдээлэл: Тухайн өрхөд харьяалах баг, хорооноос олгосон 13 оронтой “Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар”-ыг бичнэ. Тухайн өрхийн тэргүүлэгчийн овог, нэр, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

II. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ

1.Үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал, бусад: Үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал болон бусад ургамлын тариалсан талбайг бүгд дүн, усалгаатай талбай гэсэн ангиллаар 1-23 дугаар мөрөнд өгөгдсөн ургамлын нэр төрөл бүрээр асууж бүртгэнэ. Нийт тариалсан талбайн дүнгээс усалгаатай талбайн дүнг сугалж нөхнө.

1 дүгээр баганад тухайн жилд үр суулган, тариалалт хийсэн нийт талбай дүнг асууж нөхнө.

2 дугаар баганад усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалалтын явцад ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайн хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. **(Багана1≥багана2)**

1-8 дугаар мөрөнд үр тарианы тариалсан талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Үр тарианы тариалсан талбайг буудай, арвай, овьёос, хөх тариа, бог будаа, гурвалжин будаа, бусад гэсэн төрлөөр ангилан, бүртгэнэ. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийг үр тарианы тариалсан талбайд оруулахгүй. **(Мөр1=мөр(2:8))**

9 дүгээр мөрөнд төмсний тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө.

10-15 дугаар мөрөнд тэжээлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Мал амьтныг тэжээх зориулалтаар тариалсан ургамлыг тэжээлийн ургамлын тариалсан талбайд хамруулна. Тэжээлийн ургамлын тариалсан талбайг ногоон тэжээл, олон наст, даршны ургамал, бусад ургамлын тариалсан талбай гэсэн төрлөөр ангилан нөхнө. **(Мөр10=мөр(11+12+14+15))**

11 дүгээр мөрөнд ногоон тэжээлийн тариалсан талбайн хэмжээг асууж, нөхнө. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийг тариалсан талбайг ногоон тэжээлийн тариалсан талбайд хамруулна.

12 дугаар мөрөнд даршны ургамлын тариалсан талбайн хэмжээг нөхнө. Даршны ургамлын тариалсан талбайд малын тэжээлийн зориулалтаар тариалсан эрдэнэшиш, наранцэцэг зэрэг ургамлын тариалсан талбайн хэмжээг хамруулна.

13 дугаар мөрөнд даршны ургамлын тариалсан талбайгаас эрдэнэшишийн тариалсан талбайг ялгаж, нөхнө. **(Мөр12≥мөр13)**

14 дүгээр мөрөнд олон наст ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалаад 2 ба түүнээс дээш жил ургац авдаг олон наст ургамлын тариалсан талбайг үүнд хамруулна. Тухайлбал, царгас.

15 дугаар мөрөнд дээрх ангилалд хамрагдаагүй бусад төрлийн тэжээлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө.

16-20 дугаар мөрөнд техникийн ургамлын тариалсан талбайг асууж нөхнө. Үйлдвэрийн аргаар боловсруулан төрөл бүрийн бүтээгдэхүүн гарган авах зорилгоор тариалсан техникийн ургамлын тариалсан талбайг үүнд хамруулна. Техникийн ургамлын тариалсан талбайг чихрийн манжин, рапс, наранцэцэг, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. Рапс, наранцэцгийн тариалсан талбайн хэмжээ нь тосны ургамлын тариалсан талбайн хэмжээ болно. **(Мөр16=мөр(17:20))**

21 дүгээр мөрөнд зөвхөн усалгаатай хадлангийн дүнг нөхнө.

22 дугаар мөрөнд эмийн ургамлын тариалсан талбайг асууж нөхнө.

23 дугаар мөрөнд маягтад тусгагдаагүй бусад нэр төрлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг нөхнө.